ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Ховд аймгийн Жаргалант сумын Прогресс сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Аудитын код: ХОА-2022/128/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2023 он | Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn<br>Аудитор: Ц.Бадрал<br>Утас: 91983443<br>цахим хаяг: Badralts@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
**3.5.1 Төсвийн төлөвлөлт** ........ 14
**3.5.2 Төсвийн гүйцэтгэл** ........ 14
**3.5.3 Нэмэлт төсөв** ........ 15
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 15
**4.1 Ерөнхий зүйл** ........ 15
**4.2 Материаллаг байдал** ........ 16
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 16
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 16
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 16
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 17
**4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн** ........ 17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 17
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 17
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 17

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.10 № 02/22

танай __________-ны № __________-т

ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ПРОГРЕСС СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ З.ЭНХБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын Прогресс сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Жаргалант сумын Прогресс сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр гэрээний дагуу 2 ширхэг суурин компьютер, 3 ширхэг ухаалаг самбарын үнэ 37.6 сая төгрөгийг шилжүүлэн цахим худалдан авалт хийснээс хөрөнгө ирээгүй авлагаар бүртгэсэн, мөн 4 дүгээр сарын 21-ний өдөр цахим хуудас хийлгэхэд 1.0 сая төгрөг гэрээний дагуу шилжүүлсэн боловч цахим хуудас бүрэн хийгдэж дуусаагүй байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант хугацаанд Боловсрол шинжлэх ухааны газраас 22.9 сая төгрөгийг сурах бичиг, морин хуур, түрээсийн сурах бичиг, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 2.4 сая, Боловсролын мэдээллийн технологийн төвөөс 1.5 сая төгрөгийн сүлжээний тоног төхөөрөмж, боловсрол шинжлэх ухааны яамнаас 17.4 сая төгрөгийн ном ариутгагч, эцэг эхчүүдийн хандиваар 3.8 сая төгрөгийн оноонь самбар, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газраас 2.4 сая төгрөгийн номыг тус тус үнэ төлбөргүйгээр, 142.6 сая төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, батлагдсан төсвийг 169.4 сая төгрөгийг хэмнэжээ.

**Бусад асуудлын хэсэг**

Тус сургууль нь 928 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаас 2022 онд 39 бүлэгт 1457 хүүхэдтэйгээр 63 багштай, 88 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

2022 онд 11 зорилт 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг тооцон Жаргалант сумын Засаг даргад хүргүүлжээ.

2022 онд хийсэн багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр I түвшний багш-1, II түвшний багш -9, III түвшний багш -10, бусад багш нар IV түвшинд шалгагдсан ба нийт оноогоор 73.6% авч аймгийн дунджаас 3.7%, улсын дунджаас 1.1% ахисан амжилтыг үзүүллээ.

Тус сургууль нь 2022 онд 1-5 дугаар ангийн 15 бүлэгт нийт 99,894 хүүхэд өдөр үдийн хоол арга хэмжээг хэрэгжүүлж 149.8 сая төгрөгийг зарцуулжээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **161,141,577.63** | **398,923,420.01** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **-** | **169,489,369.24** |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | - | 169,489,369.24 |
| **3121** | **Төгрөг** | - | 169,489,369.24 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 169,489,369.24 |
| **33** | **АВЛАГА** | **13,000,452.00** | **39,077,800.00** |
| **335** | **Бусад авлага** | 13,000,452.00 | 39,077,800.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 13,000,452.00 | 38,577,800.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 500,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **148,141,125.63** | **190,356,250.77** |
| **351** | **Түүхий эд материал** | 3,218,165.00 | 607,760.00 |
| 35130 | Эм боох материал | 3,218,165.00 | 607,760.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **144,922,960.63** | **189,748,490.77** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 965,800.00 | 1,671,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 686,400.00 | 1,363,600.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 143,270,760.63 | 186,713,490.77 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,656,682,010.26** | **1,700,524,281.80** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,656,682,010.26 | 1,700,524,281.80 |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,533,382,010.26** | **1,577,224,281.80** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,553,545,436.29 | 1,553,545,436.29 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (162,744,031.83) | (208,884,541.11) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 197,416,188.00 | 281,859,036.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (182,964,925.88) | (197,208,412.60) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 141,732,276.00 | 151,284,476.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (103,541,453.87) | (119,828,496.83) |
| 39217 | Ном | 89,938,521.55 | 116,456,784.05 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **123,300,000.00** | **123,300,000.00** |
| 39301 | Программ хангамж | 350,000.00 | 350,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (350,000.00) | (350,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 123,300,000.00 | 123,300,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,817,823,587.89** | **2,099,447,701.81** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,817,823,587.89** | **2,099,447,701.81** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,817,823,587.89** | **2,099,447,701.81** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,566,407,787.00 | 3,566,407,787.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **(1,887,954,771.21)** | **(1,606,330,657.29)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (1,887,954,771.21) | (1,887,954,771.21) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 281,624,113.92 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 139,370,572.10 | 139,370,572.10 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,817,823,587.89** | **2,099,447,701.81** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,590,265,783.51** | **2,462,756,468.04** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **67,860,990.51** | **106,090,068.04** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **67,860,990.51** | **106,090,068.04** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 67,860,990.51 | 106,020,068.04 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 58,986,500.00 | 44,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 2,250,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 8,274,490.51 | 50,458,768.04 |
| 120009 | Бусад орлого | - | 70,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,522,404,793.00** | **2,356,666,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,233,197,900.00** | **2,020,705,200.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,233,197,900.00 | 2,020,705,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **45,469,506.00** | **10,485,000.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 7,125,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 45,469,506.00 | 3,360,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **243,640,100.00** | **325,476,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 243,640,100.00 | 325,476,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **97,287.00** | **-** |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 97,287.00 | - |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,615,258,654.68** | **2,181,132,354.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,615,258,654.68** | **2,181,132,354.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,557,665,011.63** | **2,030,290,932.12** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,042,466,633.99** | **1,415,378,763.00** |
| 210101 | Үндсэн цалин | 694,544,289.00 | 1,288,825,083.00 |
| 210102 | Нэмэгдэл | 293,629,944.99 | 80,194,714.00 |
| 210104 | Урамшуулал | 54,292,400.00 | 46,358,966.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **140,733,200.00** | **175,708,190.76** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 99,034,500.00 | 121,216,494.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,424,700.00 | 14,254,587.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,339,800.00 | 11,383,510.05 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,084,900.00 | 2,619,230.28 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,849,300.00 | 26,234,368.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **253,255,400.00** | **280,123,178.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,380,799.30 | 7,399,578.00 |
| 210302 | Түлш, халаалт | 221,426,392.70 | 240,451,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 27,448,208.00 | 32,272,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,141,195.00** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 2,134,900.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 172,600.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 877,595.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 105,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 851,100.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **8,358,341.96** | **2,353,555.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,125,441.96 | 2,353,555.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,232,900.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,850,400.00** | **-** |
| 210604 | Урсгал засвар | 3,850,400.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **112,000.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 112,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,863,900.00** | **12,678,300.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,855,900.00 | 9,311,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 3,367,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **94,883,940.68** | **144,048,945.36** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 600,200.00 | 41,735,379.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,234,926.45 | 25,642,527.40 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 72,048,814.23 | 76,671,038.96 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **57,593,643.05** | **150,841,422.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **56,340,648.00** | **149,841,000.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 42,422,700.00 | 149,841,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,917,948.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,252,995.05** | **1,000,422.00** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,252,995.05 | 1,000,422.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-24,992,871.17** | **281,624,113.92** |
| **V** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-24,992,871.17** | **281,624,113.92** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,581,991,293.00** | **2,411,797,700.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **59,586,500.00** | **55,131,300.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **59,586,500.00** | **55,131,300.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **59,586,500.00** | **55,061,300.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 58,986,500.00 | 43,500,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 2,250,000.00 |
| 120009 | Бусад орлого | - | 70,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,659,877,180.00** | **2,356,666,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,233,197,900.00** | **2,020,705,200.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,233,197,900.00 | 2,020,705,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **45,469,506.00** | **10,485,000.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 7,125,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 45,469,506.00 | 3,360,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **243,640,100.00** | **325,476,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 243,640,100.00 | 325,476,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **97,287.00** | **-** |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 97,287.00 | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,581,991,293.00** | **2,242,308,330.76** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,581,991,293.00** | **2,242,308,330.76** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,524,300,362.95** | **2,091,466,908.76** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,042,466,633.99** | **1,401,555,884.76** |
| 210101 | Үндсэн цалин | 690,506,633.99 | 960,716,161.06 |
| 210102 | Нэмэгдэл | 297,667,600.00 | 368,568,212.70 |
| 210104 | Урамшуулал | 54,292,400.00 | 72,271,511.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **140,733,200.00** | **189,530,617.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 99,034,500.00 | 128,875,556.95 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,424,700.00 | 15,288,254.07 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,339,800.00 | 12,364,803.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,084,900.00 | 2,999,935.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,849,300.00 | 30,002,067.39 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **253,255,400.00** | **280,123,178.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,700,000.00 | 7,399,578.00 |
| 210302 | Түлш, халаалт | 215,283,000.00 | 240,451,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 32,272,400.00 | 32,272,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **7,322,953.00** | **-** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,540,758.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 172,600.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,746,895.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 500,800.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,099,100.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,262,800.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **2,693,849.96** | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 976,199.96 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,717,650.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,285,200.00** | **2,485,200.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,285,200.00 | 2,485,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **112,000.00** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 112,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **13,868,900.00** | **25,867,400.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,860,900.00 | 9,311,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 16,556,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **61,562,226.00** | **191,904,629.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,600,000.00 | 163,686,929.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 47,962,226.00 | 28,217,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **57,690,930.05** | **150,841,422.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **56,437,935.00** | **149,841,000.00** |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 97,287.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 42,422,700.00 | 149,841,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,917,948.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,252,995.05** | **1,000,422.00** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,252,995.05 | 1,000,422.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **137,772,387.00** | **169,489,369.24** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **137,772,387.00** | **169,489,369.24** |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 169,489,369.24 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,566,407,787.00 | 139,370,572.10 | -1,862,961,900.04 | 1,842,816,459.06 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | -24,992,871.17 | -24,992,871.17 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,566,407,787.00 | 139,370,572.10 | -1,887,954,771.21 | 1,817,823,587.89 |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 281,624,113.92 | 281,624,113.92 |
| 19 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,566,407,787.00 | 139,370,572.10 | -1,606,330,657.29 | 2,099,447,701.81 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,408,417,700.00** | **2,237,947,908.76** | **170,469,791.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,408,417,700.00** | **2,237,947,908.76** | **170,469,791.24** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,251,301,900.00** | **2,088,106,908.76** | **163,194,991.24** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,555,908,100.00** | **1,401,555,884.76** | **154,352,215.24** |
| 210101 | Үндсэн цалин | 1,159,478,600.00 | 960,716,161.06 | 198,762,438.94 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 365,411,200.00 | 368,568,212.70 | -3,157,012.70 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 0.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 31,018,300.00 | 72,271,511.00 | -41,253,211.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **194,537,600.00** | **189,530,617.00** | **5,006,983.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 132,285,700.00 | 128,875,556.95 | 3,410,143.05 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,488,400.00 | 15,288,254.07 | 200,145.93 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,524,900.00 | 12,364,803.25 | 160,096.75 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,112,600.00 | 2,999,935.34 | 112,664.66 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,126,000.00 | 30,002,067.39 | 1,123,932.61 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **281,123,600.00** | **280,123,178.00** | **1,000,422.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,400,000.00 | 7,399,578.00 | 1,000,422.00 |
| 210302 | Түлш, халаалт | 240,451,200.00 | 240,451,200.00 | 0.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 32,272,400.00 | 32,272,400.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,485,200.00** | **2,485,200.00** | **0.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,485,200.00 | 2,485,200.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **25,883,100.00** | **25,867,400.00** | **15,700.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,311,300.00 | 9,311,300.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,571,800.00 | 16,556,100.00 | 15,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **191,364,300.00** | **188,544,629.00** | **2,819,671.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 166,506,600.00 | 163,686,929.00 | 2,819,671.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24,857,700.00 | 24,857,700.00 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **157,115,800.00** | **149,841,000.00** | **7,274,800.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **157,115,800.00** | **149,841,000.00** | **7,274,800.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 157,115,800.00 | 149,841,000.00 | 7,274,800.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,408,417,700.00** | **2,407,437,278.00** | **980,422.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,020,705,200.00** | **2,020,705,200.00** | **0.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,020,705,200.00 | 2,020,705,200.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **325,476,200.00** | **324,475,778.00** | **1,000,422.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 325,476,200.00 | 324,475,778.00 | 1,000,422.00 |
| **12** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **62,236,300.00** | **62,256,300.00** | **-20,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 55,111,300.00 | 55,131,300.00 | -20,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,125,000.00 | 7,125,000.00 | 0.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 169,489,369.24 | 0.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **3,360,000.00** | **-3,360,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **3,360,000.00** | **-3,360,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **0.00** | **3,360,000.00** | **-3,360,000.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **0.00** | **3,360,000.00** | **-3,360,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 3,360,000.00 | -3,360,000.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **0.00** | **3,360,000.00** | **-3,360,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0.00** | **3,360,000.00** | **-3,360,000.00** |
| 131101 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 3,360,000.00 | -3,360,000.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Жаргалант сумын Прогресс сургууль нь 2022 оны хичээлийн жилийг “Эрүүл бие бялдартай, зөв хандлагатай, мэдлэгээ хэрэглээ болгодог, бүтээлч хүүхэдтэй болно” гэсэн зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Энэхүү зорилгынхоо хүрээнд “Эрүүл бие бялдартай хүүхдийг төлөвшүүлж эрүүл зөв дадлыг хэвшүүлнэ”, “Зөв зерэг хандлагатай хүүхдийг төлөвшүүлнэ”, “Мэдлэгээ хэрэглээ болгоход анхаарч бүтээлч хүүхдийг төлөвшүүлнэ” гэсэн тэргүүлэх зорилт тавин ажиллажээ.

Прогресс сургууль нь 4 заах аргын нэгдэлд сургалт бусад үйл ажиллагаа явуулдаг ба байгалийн ухааны заах аргын нэгдэлд-25, нийгмийн ухааны заах аргын нэгдэлд -25, бага ангийн заах аргын нэгдэлд-16, захиргаа аж ахуйн заах аргын нэгдэлд-22, нийт 88 багш ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус сургууль нь бага ангийн-15, дунд, ахлах ангийн-48 багштай. Зөвлөх 3, тэргүүлэх 24, заах аргач 17, зэрэггүй 10 нийт багш нарын 69.8% нь мэргэжлийн зэрэгтэй, 42 багш бакалавр, 21 багш магистр зэрэгтэй байна. Нийт багш нар 100% багшлах эрхтэй.

2022 онд хийсэн багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр I түвшний багш-1, II түвшний багш -9, III түвшний багш -10, бусад багш нар IV түвшинд шалгагдсан ба нийт оноогоор 73.6% авч аймгийн дунджаас 3.7%, улсын дунджаас 1.1% ахисан амжилтыг үзүүллээ.

Жаргалант сумын Прогресс сургууль нь 2022-2023 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид 141 сурагч элсэж, 39 бүлэгт 1457 сурагч суралцаж, анги дүүргэлтийн дундаж 36.6 ба бага анги буюу 1-5 дугаар ангийн 15 бүлэгт 685, дунд анги буюу 6-9 дүгээр ангийн 15 бүлэгт 538, ахлах анги буюу 10-12 дугаар ангийн 9 бүлэгт 237 сурагч суралцаж байна. Нийт шилжиж ирсэн 87, шилжиж явсан 53 сурагч байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд Боловсролын тухай хуульд 3 удаа, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд 2 удаагийн өөрчлөлт оржээ.

Боловсролын байгууллагын багш ажилтанд үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох журмуудад өөрчлөлт орсон байна. 2022 онд боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах, багшийн хөгжлийг дэмжих, цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах журмыг шинээр баталжээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Жаргалант сумын Прогресс сургуулийн даргын 2022 оны 06 дугаар сарын 10-ны А/41 дүгээр тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлуудыг зохион байгуулсан байна.

Мөн 2022 онд Ховд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийж, бараа материал бодитоор оршин байхгүйтэй холбоотой 1.5 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, номыг тушаал шийдвэргүйгээр орлогод авсан, хүүхдийн баярын бэлгэд 0.7 төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас санхүүжүүлсэн, 6 багшид элсэлтийн ерөнхий шалгалтад 700-аас дээш оноо авсан үндэслэлээр 0.9 сая төгрөг олгосон байхад аймгийн Боловсролын газраас 4.3 сая төгрөгийн санхүүжилтээр элсэлтийн ерөнхий шалгалтын урамшуулал олгосон, сургалтын менежерүүдэд гүнзгийн нэмэгдэл олгохдоо гүнзгийн сургалттай холбоотой ажлын тайлан, ажилласан цагийн тооцоо зэрэг баримтуудад үндэслэхгүйгээр урамшуулал олгосон, Захирлын зарим ур чадвар олгох тухай тушаал Засгийн газрын 392 дугаар тогтоолыг буюу үндэслэлгүй тогтоолд үндэслэж гаргасан, архивын баримтад зарим тушаал /А/91/ тушаал, шийдвэр байхгүй байгаа зэрэг зөрчлүүд илрүүлж зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Прогресс сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын Прогресс сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 108.9 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 169,489.4 | 169,489.4 |
| Авлага | 13,000.5 | 39,077.8 | 26,077.3 |
| Бараа материал | 148,141.1 | 190,356.2 | 42,215.1 |
| Үндсэн хөрөнгө | 1,656,682.0 | 1,700,524.3 | 43,842.3 |
| **Нийт хөрөнгө** | **1,817,823.6** | **2,099,447.7** | **281,624.1** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,817,823.6 | 2,099,447.7 | 281,624.1 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,817,823.6** | **2,099,447.7** | **281,624.1** |

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 169.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- 2021 оны эцэст 13.0 сая төгрөгийн авлагатай байсан. "Цахим засаглал" үндэсний хөтөлбөр, "Ховд аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл", аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу ерөнхий боловсролын сургуулиудад сүүлийн үеийн цахим технологи ашиглан сургалт явуулах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Санко маркетинг монголиа ХХК-иас ухаалаг дэлгэцийг худалдан авахад 13.0 сая төгрөгийг шилжүүлж авлагад бүртгэсэн. 2022 онд ухаалаг самбарыг хүлээн авч данс бүртгэлд тусгаж авлагыг барагдуулсан байна.
- 2022 оны эцэст 39.1 сая төгрөгийн авлагатай байна. Энэ нь 10-р ангийн 1 сурагчийн сургалтын төлбөрийн авлага 0.5 сая төгрөг, Саммит компьютер технологи ХХК-аас 37.6 сая төгрөгийн ухаалаг самбар, суурин компьютер хугацаандаа багтаж ирээгүй, цахим хуудас хийлгэхээр 1.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч цахим хуудсыг хүлээн аваагүй тул авлагад бүртгэсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,020.7 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 44.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,065.3 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 398.3 сая төгрөгөөр, зардлыг 398.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлагдсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны орон нутгийн батлагдсан төсвийг 72.8 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,020.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 62.3 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 325.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийт 2,408.4 сая төгрөгийг бүрдүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,020.7 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 62.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 325.4 сая төгрөг, нийт 2,408.4 сая төгрөг бүрдүүлж, орон нутгийн хөгжлийн сангаас 3.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,237.9 сая төгрөг 92.9 хувьтай байгаа бөгөөд 1.0 сая төгрөгийг төвлөрүүлж дансны үлдэгдэл 169.5 сая төгрөг байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ерөнхий боловсрол / байр ашиглалт 71802/80226 | 6,628.7 | 6,628.7 | - | 100% |
| 2 | Ерөнхий боловсрол / сургалт семинар 71802/80312 | 3,314.4 | 3,314.4 | - | 100% |
| 3 | Ерөнхий боловсрол / эрүүл мэндийг дэмжих 71802/81605 | 7,623.0 | 4,898.0 | 2,725.0 | 64,25% |
| 4 | Ерөнхий боловсрол / үдийн цай 71802/81801 | 157,115.8 | 149,841.0 | 7,274.8 | 95,37% |
| 5 | Ерөнхий боловсрол / зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр 71802/81816 | 85,415.0 | 85,415.0 | - | 100% |
| 6 | Ерөнхий боловсрол / боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх 71802/81823 | 14,914.6 | 14,870.0 | 44.6 | 99,70% |
| 7 | Ерөнхий боловсрол / боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 71802/81834 | 1,651,611.1 | 1,492,236.13 | 159,375.0 | 90,35% |
| 8 | Ерөнхий боловсрол / сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 71802/81835 | 94,082.6 | 94,082.6 | - | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | Ерөнхий боловсрол / гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчныг сайжруулах 71802/81844 | 45,800.0 | 45,750.0 | 50.0 | 99,85% |
| 10 | Ерөнхий боловсрол / Сурах бичгийн түрээс 71802/81848 | 9,311.3 | 9,311.3 | - | 100% |
| 11 | Ерөнхий боловсрол / ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан 71802/83602 | 7,125.0 | 7,125.0 | - | 100% |
| 12 | Ерөнхий боловсрол / Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал 71802/80111 | 283,608.8 | 282,608.4 | 1,000.4 | 99,64% |
| 13 | Ерөнхий боловсрол / Нийтлэг үйлчилгээ 71802/80112 | 41,867.4 | 41,867.4 | - | 100% |
| | **ДҮН** | **2,408,417.7** | **2,237,947.9** | **170,469.8** | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар сургалтын төлбөрийн 43.3 сая төгрөг, түрээсийн номын төлбөр 5.9 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас багш нарын замын зардалд 3.4 сая төгрөг, нийт 52.6 сая төгрөгийг бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын Прогресс сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ц.Бадрал 2023 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс 02 дугээр сарын 08-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,615.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 32.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 25.8 сая төгрөгөөр тогтоосон байсан бол гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,181.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 43.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 34.9 сая төгрөгөөр буюу 9.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

*Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.*

Ховд аймгийн Жаргалант сумын Прогресс сургууль нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 9 дүгээр зүйлд заасан албан томилолтын зардал, 11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой ямар нэгэн зардал гараагүй байна.

12 дугаар зүйлд заасан бусад хангамжтай холбоотой гар утасны зардалд 3.3 сая төгрөгийн зардал гарсан ба энэ нь 72 багш нарын дата хэрэглээнд Боловсрол шинжлэх ухааны сайдын баталсан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах журмын дагуу зарцуулагдсан байна.

14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалтын хүрээнд 84.9 сая төгрөгийн таблет, зөөврийн компьютер, ухаалаг самбар, суурин компьютерын худалдан авалт хийгдсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Засгийн газрын шагналд дагалдах мөнгөн шагнал олгосонтой холбоотой 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10 хувиас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, төсөвт төвлөрүүлээгүйтэй холбоотой 126.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 400.0 | 1 | 400.0 | 100 |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 1 | 126,300.0 | 1 | 126,300.0 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **126,700.0** | **2** | **126,700.0** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Саммит компьютер технологи компанид ХОАЖЕБПС/001/003 тоот гэрээний дагуу 2 ширхэг суурин компьютер, 3 ширхэг ухаалаг самбарын үнэ 37.6 сая төгрөгийг шилжүүлэн цахим худалдан авалт хийснээс хөрөнгө ирээгүй авлагаар бүртгэсэн байгааг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.0 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 1.0 сая төгрөгийн алдааг залруулав.

Үүнд: Байгууллагын албан ёсны цахим хуудсыг шинээр хийлгэхээр гэрээ байгуулан мөнгийг шилжүүлсэн бөгөөд цахим хуудсыг албан ёсоор хүлээн аваагүй байхад хөрөнгөд бүртгэснийг залруулж бүртгэв.

Аудитаар мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан, хайнга хандсан, зөрчил[2] илэрсэнгүй.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| лдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Данс бүртгэлд буруу тусгасан | 1 | 1,000.0 | | | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | | | | |
| Дүн | **1** | **1,000.0** | | | **1** | **1,000.0** | **1** | **1,000.0** | **0** | **0** | **0** | **0** |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**АУДИТОР: Ц.БАДРАЛ**